

Баялаг бүтээгч үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, иргэний бизнес эрхлэх таатай орчин, тогтвортой байлгах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.

Худалдаа, үйлчилгээ шинээр эрхлэх, үйл ажиллагаагаа өргөжүүлэх хүсэлтэй аж ахуйн нэгж, иргэдийг бодлогоор дэмжиж ажиллана. Үүнд:

Сайханы хөтөл, Цагаан эрэг цогцолбор, Орхон голын эрэг зэрэг газруудад аялал жуулчлалын чиглэлээр, улирлын чанартай болон байнгын худалдаа, үйлчилгээний газар ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх



ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ, ХӨТӨЛБӨРӨӨР ДЭМЖИХ

“Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээ”-н дээр 40 хувиар нэмэгдүүлэн цалинжуулж байна. Мөн орон нутагт ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад 5 жил тутамд сүүлийн 6 сартай тэнцэх хэмжээний мөнгөн олговор олгохоор төрийн албаны тухай хуулинд нэмэлт өөрчлөлт орж 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхлэхээр болсон. 2024 онд төрийн албанд таваас дээш жил ажилласан төрийн захиргааны албан хаагчид уг нэмэгдлийг олгоно.



НЭЭЛТТЭЙ СЭЛЭНГЭ



ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

СҮХБААТАР СУМЫН ОНЦЛОГ, ДАВУУ ТАЛ:

1926 оноос Союзторгфлотын хөлгийг 10 жилийн хугацаатай ашиглах болсноор худалдааны ажил өргөжиж чийдэнгийн хороо, мал авдаг Скотимпорт, Монгол тээх, Ноос угаалгын газар, банк, холбоо, клуб, соёл ахуйн үйлчилгээний том жижиг салбарууд, 1933 онд усан онгоцны зогсоол, 1937 онд Цагаан-Эрэг хотын захиргаа байгуулагдсанаар Сүхбаатар хотын суурь тавигдаж, улмаар БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1938 оны 4-р сарын 19-ний шийдвэрээр “Цагаан эрэг” хотыг “Сүхбаатар хот” хэмээн нэрлэсэн байна.



Сүхбаатар сум

Омега Ал Баруун



99070184



<http://Sukhbaatar.se.gov.mn/>

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хот нь Монгол улсын хойморт орших бөгөөд Монголын тулгар төрийн үүсэл хөгжлийн үе үеийн түүхэнд стратегийн түшиц газар болж байснаараа онцлог юм.

Сүхбаатар сум нь Улаанбаатар хотоос 330 км, Дархан-Уул аймгаас 100 км, Алтанбулаг сумаас 24 км зайд байрладаг. Ази европыг холбосон Олон улсын төмөр болон авто замаар холбогдсон зам харилцаа, дэд бүтэц бүрэн хөгжсөн аймгийн төв суурин газар.

Сүхбаатар сум нь нийт 4535 га талбай бүхий газар нутагтай ба хойд талаараа Баянхаан уул, өмнө талаараа Орхон гол, зүүн талаараа Буурхээрийн тал, Түжийн нарс, баруун талаараа Сэлэнгэ их мөрөн, Сайхны хөтөл зэрэг түүхт газраар хиллэдэг, байгалийн үзэсгэлэнт Монгол орны тусгаар тогтнолын түүхт нутаг юм.



Сэлэнгэ аймгийн төв Сүхбаатар суманд 230-н аж ахуй нэгж байгууллага үйл ажиллагаа явуулдаг. Аймгийн Засаг даргын Тамгын газар болон эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч 49 агентлагууд Сүхбаатар суманд байрладаг.

Ерөнхий боловсролын 7-н сургууль, 8-н цэцэрлэг, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн 2 газарт нийт 789 төрийн албан хаагч ажиллаж байна

СҮХБААТАР СУМЫН ХӨГЖИХ БОЛОМЖ:

Сүхбаатар сум нь Монгол улсын хилийн боомт хот, Хувьсгалын өлгий, байгалийн үзэсгэлэн бүрдсэн нутаг бөгөөд аялал жуулчлал, усан зам тээвэр, хил орчмын худалдаа, аж үйлдвэрлэл хөгжүүлэх өргөн боломжтой.

Зам харилцаа, эрчим хүч дэд бүтэц сайтай. Ижил төстэй муж, хотуудтай шууд болон уламжлалт харилцаатай.

Сэлэнгэ аймгийн төв Сүхбаатар сумыг хилийн боомт хот болгон хөгжүүлснээр аж үйлдвэрийн, тээвэр ложистикийн төвүүдийг байгуулах, аялал жуулчлалыг хөгжүүлснээр ОХУ-ын хилээр орж ирж буй аялагчийн тоо нэмэгдэж худалдаа үйлчилгээ бизнес эрхлэгчид тус суманд аялан саатах, бизнес

худалдаа хийх, хотын тээвэр, ложистикийн төвөөр дамжуулан бараа бүтээгдэхүүнийг гуравдагч орон руу гаргах буюу Ази-Европыг дамжсан улс хоорондын худалдаа, тээврийн харилцааны гол салбар болгох зорилтыг үе шаттайгаар хэрэгжүүлэх, дотоодын аймаг, хот руу тээвэрлэх гэх мэт хүн амын төвлөрөл бүхий хот болох бүрэн боломжтой юм.



Сумын төвд Их дээд сургууль байгуулах, Эрчимжсэн мал аж ахуй, өрхийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, өрхийн хэмжээнд төмс хүнсний ногоо тариалах, хүлэмжийн аж ахуй эрхлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх үндсэн суурь үзүүлэлтүүд бүрэн бүрдсэн.



ХОТ ХӨДӨӨГИЙН СЭРГЭЛТИЙН ХҮРЭЭНД:

Сүхбаатар суманд дараах ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж байна. Үүнд:

1. 50 мв-ын хүчин чадалтай Дулааны цахилгаан станц барих судалгааны ажил хийгдэж 5 дугаар багийн нутаг дэвсгэр дээр барихаар төлөвлөн ажлаа эхлүүлээд байна. 2026 онд ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна.
2. Дахин төлөвлөлтийн ажлын хүрээнд Ганзам 7 дугаар багийн хоёр найман айлын орон сууцыг дахин төлөвлөлтөд оруулж, бүрэн цутгамал 230 айлын "Сүлд өргөө" хотхон баригдаж байна.
3. Баянхаан 4 дүгээр багийн нутаг дэвсгэр дээр 600 айлын "Сэлэнгэ мөрөн" хотхон нийт 830 айлын орон сууц баригдахаар ажлаа эхлүүлээд байна.

Танай сумыг зорин ирэх иргэдэд ямар боломж нөхцөл олгох вэ?

